

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн /орон нутгийн төсөв / 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/52-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сүхбаатар сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: Т.Одсүрэн Утас: 70362442 Цахим хаяг: odsurent@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3-4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-8
3.Аудитын тайлан.....	9
3.1. Ерөнхий зүйл.....	9
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9-10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4. Материаллаг байдал	10-11
3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11-12
3.8. Аудитын гол асуудал	12
3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.10. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12-13
4. Аудитын илрүүлэлт	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НА	Нотлох ажил
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СЭА	Сэлэнгэ аймаг
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.11 № СЭА-2022/52-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА Л.ЗОРИГТБААТАР ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн /орон нутгийн төсөв/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн /орон нутгийн төсөв/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		4 171 433.96
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		МНО 10065 9055436
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө		
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө		
31210	Төгрөг		
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
33	АВЛАГА		
33500	Бусад авлага		
34	УРЬДЧИЛГАА		
35	БАРАА МАТЕРИАЛ		
35100	Түүхий эд материал		
35400	Хангамжийн материал		
36	НӨӨЦИЙН БАРАА		
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		
39200	Биет хөрөнгө		
39300	Биет бус хөрөнгө		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		
51	Засгийн газрын хувь оролцоо		
51200	Хуримтлагдсан үр дүн		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	116,469,073.33	66,435,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	631,173.33	-
120	Нийтлэг татварын бус орлого	631,173.33	-
120002	Хүүгийн орлого	156,173.33	-
120009	Бусад орлого	475,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	115,837,900.00	66,435,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	115,837,900.00	66,435,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	115,837,900.00	66,435,500.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	116,469,073.33	66,435,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	116,469,073.33	66,435,500.00

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	631,173.33	2,035,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	790,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	790,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	1,245,500.00
210702	Дотоод албан томилолт	-	1,245,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	631,173.33	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	631,173.33	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	115,837,900.00	64,400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	115,837,900.00	64,400,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	115,837,900.00	64,400,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-	-
VI-I	Засгийн газрын хувь оролцоо	-	-
VI-II	Хяналтын бус хувь оролцоо	-	-

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Өмчид гарсан өөрчлөлт				
8	Зарласан ногдол ашиг				
9	Тайлант үеийн үр дүн				
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл				
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				

20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл			
----	--	--	--	--

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	116,469,073.33	66,435,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	631,173.33	-
120	Нийтлэг татварын бус орлого	631,173.33	-
120002	Хүүгийн орлого	156,173.33	-
120009	Бусад орлого	475,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	115,837,900.00	66,435,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	115,837,900.00	66,435,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	115,837,900.00	66,435,500.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	116,469,073.33	66,435,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	116,469,073.33	66,435,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	631,173.33	2,035,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	790,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	790,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	1,245,500.00
210702	Дотоод албан томилолт	-	1,245,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	631,173.33	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	631,173.33	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	115,837,900.00	64,400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	115,837,900.00	64,400,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	115,837,900.00	64,400,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү /хэтрэлт, хэмнэлт	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	140,539,400.00	66,435,500.00	74,103,900.00	47.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	140,539,400.00	66,435,500.00	74,103,900.00	47.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,832,600.00	2,035,500.00	2,797,100.00	42.12
2104	Хангамж, бараа материалын зардал	798,000.00	790,000.00	8,000.00	99.00
210402	Тээвэр, шатахуун	798,000.00	790,000.00	8,000.00	99.00

2107	Томилолт, зочны зардал	1,855,000.00	1,245,500.00	609,500.00	67.14
210702	Дотоод албан томилолт	1,855,000.00	1,245,500.00	609,500.00	67.14
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,179,600.00	-	2,179,600.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,179,600.00	-	2,179,600.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	135,706,800.00	64,400,000.00	71,306,800.00	47.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	135,706,800.00	64,400,000.00	71,306,800.00	47.46
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	135,706,800.00	64,400,000.00	71,306,800.00	47.46
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	140,539,400.00	66,435,500.00	74,103,900.00	47.27
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	140,539,400.00	66,435,500.00	74,103,900.00	47.27
320001	Орон нутгийн төсвөөс	140,539,400.00	66,435,500.00	74,103,900.00	47.27

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн /орон нутаг/ /цаашид Халамжийн сан гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн Амьжиргаа дэмжих зөвлөлийн үйл ажиллагаа болон онцгой тохиолдлын тэтгэмжтэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Одсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 25 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Нийгмийн халамжийн тухай хуульд зааснаар Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, нийгмийн халамжийн талаар төрөөс баримталж буй цогц бодлогыг орон нутагт чанартай, хүртээмжтэй, шуурхай хүргэх замаар иргэдийн хөдөлмөрлөх, хөгжих таатай орчин бий болгож, амьжиргааны түвшинг дээшлүүлэх.
- Хүн амын зорилтот бүлгүүдийн хэрэгцээнд тулгуурлан нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх замаар нийгмийн халамж хүртэгчээс хөдөлмөр эрхлэгч болох нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан.
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,

- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн.
- Засгийн газрын 2021 оны 362 дугаар тушаалаар Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журам шинэчлэгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Халамжийн сан нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус сангийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт дотоод аудитын нэгж байхгүй, тайлант жилийн хугацаанд харьяа дээд байгууллага болон хөндлөнгийн хяналт шалгалт хийгдээгүй боловч сангийн үйл ажиллагаатай холбоотой олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийн хувийн хэргийн бүрдүүлэлтэд дотоод хяналт шалгалтыг удирдамжийн хүрээнд 17 сумыг хамруулан, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, үнэлж дүгнэсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийн орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн орлого болох 66,435.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 664.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 465.0 мянган төгрөгөөр тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Халамжийн сангийн санхүүгийн тайланг УСНББОУС болон түүнд нийцүүлэн баталсан хууль, дүрэм, журмын хүрээнд нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бэлтгэн гаргасан байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлд " *Нийгмийн халамжийн сан нь мөнгөн хөрөнгийн сан байна*" гэж заасны дагуу халамжийн сангийн хөрөнгө нь зөвхөн мөнгөн хөрөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөөс бүрдэж байна. Өөрөөр хэлбэл Халамжийн сангийн санхүүгийн тайланд бараа материал, үндсэн хөрөнгө зэрэг хөрөнгийн бусад хэлбэрүүд тусгагдаагүй байна.

Халамжийн сангийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого болон нийт зардал тус бүр өмнөх оноос 49,402.4 мянган төгрөгөөр буюу 43.0 хувиар буурч 66,435.5 мянган төгрөгөөр тайлагнагдсан нь цар тахлын улмаас сэргээн засах үйлчилгээнд хамруулах арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сангийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 156,070.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 156,070.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 15,531.1 мянган төгрөгөөр бууруулан 140,539.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 140,539.4 мянган төгрөгийн төсөв баталж, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 66,435.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт зардлын гүйцэтгэл 66,435.5 мянган төгрөг буюу 47.3 хувьтай байгаа нь нийгмийн халамж, тэтгэвэр тэтгэмжийн зардлыг 71,306.8 мянган төгрөгөөр, дотоод албан томилолт, тээвэр шатахуун, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 2,797.1 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Цахим Монгол" хөтөлбөрийн хүрээнд төрөөс иргэдэд үзүүлж буй нийгмийн халамжийн үйлчилгээг цахим хэлбэрт үе шаттайгаар шилжүүлж байгаатай холбогдуулан орон нутгийн төсвөөс санхүүжиж байгаа олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, онцгой тохиолдлын 4 төрлийн үйлчилгээг 2021 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс арилжааны банкаар бус төрийн сангийн дансаар дамжуулан ХХҮЕГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн олгохоор болсон байна.

3.7.2 Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан бүх сумдад хүрч ажиллах боломжгүй учир Алтанбулаг, Баруунбүрэн, Мандал, Сант, Сайхан, Сүхбаатар, Жавхланта, Орхонтуул, Шаамар зэрэг 9 сумын онцгой тохиолдлын тэтгэмжийн хувийн хэрэгт түүврийн арга ашиглан тулган баталгаажуулалт хийсэн болно.

3.7.3 Санхүүгийн тайлангийн аудитад тус халамжийн сангийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудлыг бүрэн хамруулсан бөгөөд халамжийн сангаас олгож байгаа тэтгэвэр, тэтгэмжид хамрагдаж байгаа иргэдийн хувийн хэрэг, тэтгэвэр, тэтгэмж тогтоолтыг иж бүрэн тулган баталгаажуулах боломжгүй тул цаашид гүйцэтгэл, нийцлийн аудитаар авч үзэх шаардлагатай юм.

3.7.4 Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах хүсэлт гаргасан өрх, иргэний мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлж байгаатай холбогдуулан халамжийн үйлчилгээ олгох шалгуурт заасан, бүрдүүлэх баримт бичгийг мэдээллийн санд иж бүрэн оруулаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Халамжийн сангийн мэдээлбэл зохих 20 төрлийн 148 мэдээлэл байршуулахаас 146 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн бол, 1 мэдээлэл / тухайн жилийн төсөвт орсон, нэмэлт, өөрчлөлт (тухай бүр) 10, 12 сард/-ийг 2 удаа хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудсанд 5 мэдээлэл хоцроон байршуулсан зөрчлийг арилгуулах зөвлөмжийн хэрэгжилт 60 хувьтай байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Санхүүгийн тайлангийн аудитаар тус халамжийн сангаас олгож байгаа тэтгэвэр, тэтгэмжид хамрагдаж байгаа 17 сумын иргэдийн хувийн хэрэг, тэдгээрийн тогтоолттой холбоотой асуудлыг дараагийн аудитаар нарийвчлан тулган баталгаажуулах шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар дараах алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Амьжиргаа дэмжих зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж мөнгөн тусламжид хамрагдах хүсэлт гаргасан өрх, иргэний баримт бичиг, амьдралын нөхцөлийг судлан үзэж, тэдгээрийг холбогдох нийгмийн халамжид хамруулах эсэхийг шийдвэрлэх сум тосгодын “Амьжиргаа дэмжих зөвлөл”-ийн хурлаар хэлэлцсэн асуудлыг Цагааннуур сумаас бусад сумдууд бүх гишүүдийн бус зөвхөн зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргын гарын үсгээр баталгаажуулж байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2012 оны А/89 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Амьжиргаа дэмжих зөвлөлийн дүрэм”-ийн 3.4-т “Зөвлөлийн шийдвэр нь хурлын тэмдэглэлд тусгаагдах бөгөөд шийдвэрийн хэсгийг хуралдаанд оролцсон гишүүдийн гарын үсэг, тухайн сум, хорооны Засаг даргын тамгаар баталгаажуулна.” гэж заасны дагуу хуралд оролцсон гишүүдээр баталгаажуулж байх.

2. Онцгой тохиолдлын тэтгэмжтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Гэнэтийн аюул осол, урьдчилан төсөөлөх боломжгүй бусад шалтгаанаар гэр оронгүй, гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон болон амьжиргааны эх үүсвэрээ алдсан өрхөд нэг удаагийн мөнгөн тусламж олгохдоо 5 иргэний гэр оронгүй болсныг тодорхойлсон нөхцөл байдлын үнэлгээ болон харьяа эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газраас олгосон үл хөдлөх хөрөнгөтэй эсэх лавлагааг цахим бүртгэлийн системд оруулаагүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2021 оны 362 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа олгох журам”-ын 2.2, 2.3-т заасны дагуу нийгмийн халамжийн нэгдсэн цахим системд бүртгэхдээ холбогдох хууль тогтоомжид заасан шалгуур нөхцөлийг хангаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Халамжийн сан /орон нутгийн төсөв/	2	-	-	-	-	-	-	-	2	-